

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Суат” ХХК ОНӨААН-ийн

2017 оны 12 дугаар сарын 31-нээр

дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан

Аудитын код: БӨА-2018/1/СТА-ОНӨААН

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Суат” ХХК ОНӨААН-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Суат” ХХК ОНӨААН-ийн 2017 оны оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Суат” ХХК ОНӨААН-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 3 дугаар сарын 05-наас 3 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газрын аудитор Д.Назгүл хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Суат” ХХК ОНӨААН-ийн 2017 санхүүгийн тайланг 2018 оны 3 дүгээр сарын 05-нд аймаг дах Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 3 дугаар сарын 05-наас 3 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 3 дугаар сарын 16-нд “Суат” ХХК ОНӨААН-ийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Суат” ХХК ОНӨААН-ийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль зэрэг хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

"Суат" ХХК ОНӨААН-ийн "аймгийн хүн амыг стандартын шаардлага хангасан ундны цэвэр усаар хангаж, гарсан бохир усыг татан зайлуулах" эрхэм зорилгын дор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах,
- Цэвэр усны жижиг үйлдвэр,
- Бетон эдлэлийн үйлдвэр,
- Халуун усны үйлчилгээ

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д "Байгууллагын дарга тус байгууллагын төсвийн шууд захирагч байна" гэж заасны дагуу "Суат" ХХК ОНӨААН-ийн захирал төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. "Суат" ХХК ОНӨААН-ийн 2017 оны төсвийг өөрийн үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэн ажилласан байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

"Суат" ХХК ОНӨААН-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар "Суат" ХХК ОНӨААН-ийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 18-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаанд өөрийн байгууллагын боловсруулж

баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ажилласан байна. Энэхүү бодлогын баримт бичиг нь Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүй болон УСНББОУС-тай нийцсэн байна.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа программын үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Ординат” ХХК-ны “Vinicca-3.4” программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Суат” ХХК ОНӨААН-ийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг өөрийн үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлснээс гадна төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

“Суат” ХХК-ны Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2017 оны үйл ажиллагааг 816,4 сая төгрөгийн орлого оруулж, 965,2 сая төгрөгийн зардал гаргаж, -148,8 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 822,4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөөг 6,0 сая төгрөгөөр буюу 0,7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Үйл ажиллагаандаа 913,4 сая төгрөгийн зардал гаргаж, -91,1 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Батлагдсан төсөвт зардлыг 57,7 сая төгрөгөөр хэмнэж ажиллажээ. Өмнөх онд -68,6 сая төгрөгийн алдагдалтай ажиллах батлагдсан төлөвлөгөөтэй ажиллаж гүйцэтгэлээр -242,8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан ба өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад тайлант оны алдагдал өмнөх оны үзүүлэлтээс -151,7 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Тайлант оны нийт зардлын гүйцэтгэл өмнөх оноос 200,2 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй ба үүнээс 169,4 сая төгрөг нь бусад бараа үйлчилгээний зардал, 28,2 сая төгрөг нь эд хогшил, урсгал засварын зардал, 12,1 сая төгрөг нь байр ашиглахтай холбоотой тогтмол зардлын бууралт байна. Тайлант онд цалингийн зардлыг 20,4 сая төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 5,7 сая төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 5,8 сая төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 44,9 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 1,2 сая төгрөгөөр тус тус батлагдсан төлөвлөгөөнөөс хэмнэж ажилласан бол хангамж бараа материалын зардлыг 11,2 сая төгрөгөөр, бараа

үйлчилгээний бусад зардлыг 18,5 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 0,8 сая төгрөгөөр, хүүний зардлыг 0,4 сая төгрөгөөр тус тус батлагдсан төлөвлөгөөнөөс хэтрүүлж, хэмнэсэн зардлаасаа гүйлгэн зарцуулжээ.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажиллах зорилгоор shilendans.gov.mn цахим хуудсанд 2017 оны мэдээлэлээ бүрэн байршуулжээ.

2017 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар тус байгууллагын шилэн дансны үйл ажиллагаатай холбоотой алдаа, зөрчил илэрээгүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 14 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 18 нарийвчилсан болон хяналтын горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

“Суат” ХХК ОНӨААН-ийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний орлого, мөнгөн хөрөнгө, бараа материал, авлага, өглөг, цалин, НДШ-ийн зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тус байгууллагын нийт орлогын 100 хувь, нийт зардлын 100 хувийг хамруулж нарийвчилсан горим, сорилын аргаар шалгав.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг дараах алдаа зөрчил илэрсэн. Үүнд:

1. ХХОАТ-ын ногдуулалт, төлөлтийн тооцоог шалгаж үзэхэд тайлант онд олгосон цалин, түүнтэй адилтгах орлогод 28396,2 мянган төгрөгийн татвар ногдуулж, 20495,6 мянган төгрөгийг шилжүүлж, 7900,6 мянган төгрөгийн татварыг дутуу төлсөн боловч санхүүгийн тайланд 7136,8 мянган төгрөгийг өглөгөөр тусгаж, 763,6 мянган төгрөгийг дутуу тусгасан байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт дутуу төвлөрүүлсэн 763,6 мянган төгрөгийн ХХОАТ-ыг “Суат” ХХК ОНӨААН-ийн төсвөөс нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

2.НДШ-ийн ногдуулалт, төлөлтийн тооцоог шалгаж үзэхэд оны эхэнд НДШ-ийн 15604,1 мянган төгрөгийн өглөгтэй байсан ба тайлант онд олгосон цалин, түүнтэй адилтгах орлогод 80738,1 мянган төгрөгийн шимтгэл ногдуулж, 77107,9 мянган төгрөгийг шилжүүлж санхүүгийн тайланд 17636,4 мянган төгрөгийг өглөгөөр тусгаж, 1597,9 мянган төгрөгийн дутуу төлөлтийг өглөгт дутуу тусгасан байна.

Шийдвэрлэсэн нь: *Нийгмийн даатгалын хэлтэстэй НДШ-ийн 1597,9 мянган төгрөгийн дутуу төлөлтийг дахин тооцоо нийлж баталгаажуулж, барагдуулах арга хэмжээ авч ажиллах талаар албан шаардлага өгөв.*

3.Тайлант оны бараа материалын худалдан авалт, орлогод авах, зарлага гаргах ажил гүйлгээг шалгаж үзэхэд касс, харилцахаар нийтдээ 138220,1 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалт хийсэн боловч бараа материалын тодруулга тайлангийн орлого, зарлагын ажил гүйлгээнд 77798,4 мянган төгрөгийн орлогыг тусгасан буюу 60421,1 мянган төгрөгийн бараа материалын орлогод авалгүй шууд зардлаар гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: *Бараа материалын орлого, зарлагын бүртгэл, тайланг холбогдох хууль журмын дагуу хийж, тайлагнаж байхыг албан шаардлагаар үүрэг болгов.*

4. Санхүүгийн тайланд тусгасан мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг арилжааны банкуудаас ирүүлсэн харилцах дансны үлдэгдлийн баталгаатай тулгаж шалгахад банкин дахь мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлийг 22802,37 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: *Санхүүгийн байдлын тайлан, Үр дүнгийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, Цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан болон мөнгөн хөрөнгийн тодруулга тайлангуудад залруулга хийв.*

5.Тус аудитын газраас 2017 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар иргэн Б.Пернебект зориулалт бусаар олгосон 1.5 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр акт тогтоосныг байгууллагын данснаас төлж, тухайн иргэнээс барагдуулж аваагүй, үр ашиггүй зардал гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: *Б.Пернебект зориулалт бус олгосон 1.5 сая төгрөгийг нөхөн төлүүлэн авч байгууллагын дансанд оруулахыг албан шаардлагаар үүрэг болгов.*

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа зөрчил гараагүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Дараагийн аудитаар хөрөнгө, бараа материалыг худалдан авалт, орлогод авах, зарлага гаргах ажил гүйлгээг дахин хянаж шалгана..

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Суат” ХХК ОНӨААН-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар ХХОАТ, НДШ-ийн дутуу төлөлтийг санхүүгийн тайланд дутуу тусгасан 2361,5 мянган төгрөгийн, бараа материалыг шууд зарлага гаргасан 60421,1 мянган төгрөгийн, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг санхүүгийн тайланд зөрүүтэй тусгасан 22,8 мянган төгрөгийн алдаа, зөрчил, 2017 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар иргэн Б.Пернебект зориулалт бусаар олгосон 1.5 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр акт тогтоосныг байгууллагын данснаас төлж, тухайн иргэнээс барагдуулж аваагүй, үр ашиггүй зардал гаргасан нийт 64305,42017 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар иргэн Б.Пернебект зориулалт бусаар олгосон 1.5 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр акт тогтоосныг байгууллагын данснаас төлж, тухайн иргэнээс барагдуулж аваагүй, үр ашиггүй зардал гаргасан мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1 заалт бүхий зөвлөмж өгсөн ба биелэлтийг 2017 оны 11 дүгээр сарын 27-ны 166 тоо албан бичгээр ирүүлсэн байна. Зөвлөмжийн биелэлтийг аудитын явцад давтан шалгаж үзэхэд шүүхэд хандаж, шийдвэр гаргуулж авсан ба одоогоор авлагаа барагдуулж аваагүй ба Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд хандаж байгаа юм байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурьдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “Суат” ХХК ОНӨААН-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн ба илэрсэн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшингээс доогуур байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ... хуудас, албан шаардлага хуудас хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

М.ХУАНГАН

Огноо:2018.03.19

Х.ЖЕНИСБЕК

Огноо:2018.03.19

Д.НАЗГҮЛ

Огноо:2018.03.15

